



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/425

Булган сум

Иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах хяналт шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн хэмжээнд “Иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах таслан зогсоох, бууруулах хяналт шалгалт”-ыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулсугай.

2.Аймгийн онцгой комиссын гишүүдийн иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн үзлэг, хяналт шалгалт хэрэгжүүлэх хуваарийг 1 дүгээр, хяналт шалгалтын удирдамжийг 2 дугаар, төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Гамшгаас хамгаалах сангаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (дэд хурандаа Л.Пүрэвчулуун)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг удирдамж, төлөвлөгөөнд заасны дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, техник хэрэгслээр тухай бүрд нь хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсгийн дарга нар болон сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны  
06 дугаар сарын 12-ны/ний өдрийн  
А/425 дугаар захирамжийн 1 дүгээр хэвсрэлт




**АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН БОЛОН  
ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ НЭГДСЭН ҮЗЛЭГ, ХЯНАЛТ-ШАЛГАЛТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ**

д/д	Гүйцэтгэх үүрэг	Онцгой комиссын гишүүд	Байгууллага, албан тушаал
1	2	3	4
<b>1.Уул уурхайн үйл ажиллагаанд байгаль орчин, хүний аюулгүй байдлыг хангуулах үзлэг, хяналт-шалгалт зохион байгуулах чиглэлд</b>			
1	Ажлын хэсгийн дарга	Г.Давааням	Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга
2	Гишүүн	А.Гантөмөр	Байгаль орчны газрын дарга
3		Б.Ариунболд	Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
4		Ж.Болдбаатар	Онцгой байдлын газрын Орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа
<b>2.Барилга, дэд бүтцийн аюулгүй байдлыг хангуулах үзлэг, хяналт-шалгалт зохион байгуулах чиглэлд</b>			
1	Ажлын хэсгийн дарга	Г.Гантулга	Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
2	Гишүүн	Ү.Бямбасүрэн	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
3		Н.Хишигдорж	Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа
4		Г.Ганбаатар	Дулаан ус хангамж, Нийтийн аж ахуйн "Булган мээж" ОНӨХХК-ын захирал
5		Ч.Оюун	"Мэдээлэл холбооны сүлжээ" Булган аймаг дахь газрын дарга
6		Г.Отгонбаяр	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Булган салбарын захирал
<b>3.Зам, тээврийн аюулгүй байдлыг хангуулах үзлэг, хяналт-шалгалт зохион байгуулах чиглэлд</b>			
1	Ажлын хэсгийн дарга	Б.Эрдэнэбилэг	Цагдаагийн газрын дарга, хурандаа
2	Гишүүн	Н.Баасанжаргал	Булган аймаг дахь Авто тээврийн төвийн дарга
3		М.Нуваантая	Булган аймгийн Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн салбарын захирал
4		Т.Нямхүү	Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа
<b>4.Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах үзлэг, хяналт-шалгалт зохион байгуулах чиглэлд</b>			
1	Ажлын хэсгийн дарга	Д.Алтаншагай	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга
2	Гишүүн	М.Батчимэг	Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
3		Д.Нарантуяа	Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
4		Н.Пүрэвсайхан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
5		Г.Одсүрэн	Мал эмнэлгийн газрын дарга

6		М.Эрдэнэбат	Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
<b>5.Төрийн байгууллага, аж ахуй нэгжид иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах үзлэг, хяналт-шалгалт зохион байгуулах чиглэлд</b>			
1	Ажлын хэсгийн дарга	Б.Одхүү	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
2	Гишүүн	Б.Насанжаргал	Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
3		Д.Буян-Өлзий	Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа
4		Д.Бямбажаргал	Булган сумын Засаг дарга
5		Ц.Цолмонбаатар	Боловсролын газрын дарга
6		Б.Нандинбат	Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

--o00o--

А/425 06. дугаар сарын 12-ны/ний өдрийн  
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН БОЛОН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ,  
АЮУЛ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРСДЭЛИЙГ АРИЛГАХ,  
ТАСЛАН ЗОГСООХ, БУУРУУЛАХ, ҮЗЛЭГ, ХЯНАЛТ-ШАЛГАЛТЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл:**

1.1. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай, хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлыг тухай хууль, Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар, Улсын Онцгой комиссын 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 3 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дугаар 01 хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дугаар 02 албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2026 оны 06 сарын 02-ны өдрийн дугаар 03 хурлын тэмдэглэл болон холбогдох бусад дүрэм, журам, норм, стандартыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Зорилго:**

2.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн түвшинд аливаа болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангуулах, Монгол хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, аюулгүй амьдрах, ажиллах ээлтэй орчныг бүрдүүлэхэд нэгдсэн удирдамжийн зорилго оршино.

**Гурав. Зохион байгуулах хугацаа, хамрах хүрээ, оролцоо:**

3.1. Болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангуулах, нэгдсэн арга хэмжээг 2026 оны 06 дугаар сарын 15-наас 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд 16 сум, 1 тосгоны хэмжээнд сумын Засаг даргын тамгын газар удирдлагаар ханган зохион байгуулна;

3.2. Нэгдсэн арга хэмжээг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах болон гал түймэртэй тэмцэх хэсэг, сайн дурын хэсэг, багийн Засаг дарга, хэсгийн ажилтан, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах;

3.3. Орон нутагт зохион байгуулах нэгдсэн арга хэмжээнд: Аймаг, сумын Засаг даргын тамгын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Байгаль орчны газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, “Булган мээж” ОНӨХХК зэрэг байгууллагууд мэргэжлийн чиглэлээр хамтран оролцох;

3.4. Байгууллагын цахим хуудсанд аливаа болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг постер, шторкийг татан байршуулж сурталчлах.

**Дөрөв. Нэгдсэн арга хэмжээний үйл ажиллагааны чиглэл:**

4.1. Төрийн хяналт шалгалтын тухай, хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах

тухай хууль, Галын аюулгүй байдлыг тухай хууль, дүрэм, журам, норм, стандартын хэрэгжилтийг хангуулж дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

4.1.1.Иргэд, олон нийтэд аливаа болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэх, гарын авлага, санамж, сэрэмжлүүлэг тараах;

4.1.2.Иргэд, олон нийтийн оролцоог хангах, идэвх, санал санаачилгыг нэмэгдүүлэх;

4.1.3.Үзлэг-шалгалтын явцад хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох аюул, эрсдэл нь нотлогдсон, аюул, осол гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа, нутаг дэвсгэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн тухайн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд хаах, түр зогсоох арга хэмжээг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж ажиллах.

**Тав. Үр дүн, тайлан:**

5.1.Нэгдсэн арга хэмжээг заагдсан хугацаанд чанартай, үр дүнтэй зохион байгуулах, иргэд, олон нийтийн оролцоог хангуулах.


5.2.Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан ажлын явцын тайланг 2026 оны 06 дугаар сарын 19-нд биелэлтийн тайланг 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн дотор Онцгой комиссын ажлын албанд [erdenebulgan641@gmail.com](mailto:erdenebulgan641@gmail.com) ирүүлэх.

**Зургаа. Санхүүжилт:**

6.1. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийг тухайн орон нутгаас хариуцан гаргана.

--o00o--

А/125 06  
 Аймгийн Засаг даргын 2026 оны  
 06 дугаар сарын 15-ны/ний өдрийн  
 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН БОЛОН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ, АЮУЛ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
 ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, ТАСЛАН ЗОГСООХ ЧИГЛЭЛЭЭР НЭГДСЭН ҮЗЛЭГ,  
 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хамрах хүрээ	Хариуцах эзэн
1	2	3	4	5
1	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасны дагуу ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хайгуулын цооног, ухсан нүхийг бүрхэх, хаах аюулгүй байдлыг хангах, хүн мал амьтанд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	2026.06.15-06.29	Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч	АЗДТГ-ын Геологи уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Наранцацралт БОГ-ын мэргэжилтэн Б.Март БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбаяр ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Батболд
2	Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан батлах болон хэрэгжилтэд хяналт тавих	2026.06.15-06.29	Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч	БОГ-ын мэргэжилтэн Б.Март БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбаяр Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, Сумдын засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчид
3	Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хайгуулын үеийн нөхөн сэргээлтийн үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, нөхөн сэргээлтийн ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх, шаардагдах санхүүжилтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулах	2026.06.15-06.29	Нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон ашигт малтмалын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай	БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбаяр Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ БОГ-ын мэргэжилтэн Б.Март

4	Уурхайн болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны улмаас хүний амь нас эрүүл мэнд хүрээлэн буй орчинд эрсдэл учруулсан эсхүл учруулах нөхцөл бүрдүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллах	2026.06.15-06.29	Уул уурхай Дэд бүтэц-зам, барилга бусад	АЗДТГ-ын Геологи уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Наранцацралт БОГ-ын мэргэжилтэн Б.Март БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбаяр БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Батболд
		2026.06.15-06.29	Дэд бүтэц-зам, барилга бусад	АЗДТГ-ын Авто замын хяналтын улсын байцаагч С.Сүхбаатар ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч Н.Очирхуяг БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ, Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбаяр ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Батболд
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д зааснаар хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх таслан зогсоох зорилгоор уул уурхай, барилга, зам, тээвэр, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	2026.06.15-06.29	Уул уурхай	АЗДТГ- Геологи уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Наранцацралт ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Батболд Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Э.Нансалдулам БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ
		2026.06.15-06.29	Барилга	ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч У.Пунсалдулам Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Э.Нансалдулам ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч Н.Очирхуяг
		2026.06.15-06.29	Зам	АЗДТГ-ын Авто замын хяналтын улсын байцаагч С.Сүхбаатар ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Батболд Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Э.Нансалдулам БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б.Золбаяр

		2026.06.15-06.29	Тээвэр	ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч У.Пунсалдулам Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Э.Нансалдулам АТТ-ийн Авто тээврийн хяналтын улсын байцаагч Авирмэд
		2026.06.15-06.29	Боловсруулах үйлдвэрлэл	ХХҮГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Батболд Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Э.Нансалдулам БОГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч М.Хос-Эрдэнэ ГХБХБГ-ын Барилга техникийн хяналтын улсын байцаагч Н.Очирхуяг МЭГ-ын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Б.Алтанбулаг
6	Ашигт малтмалын ашиглалт хайгуулын үйл ажиллагааны улмаас үүссэн ил уурхайн ухаш, шуудуу, аюултай бүсийн улсын хэмжээний тооллого үзлэгийг зохион байгуулж, хүний амь нас эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй объектуудыг бүртгэн, эрсдэлийн зэрэглэл тогтоон, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	2026.06.15-06.29	Шалгагдсан байгууллага, объект	АЗДТГ-ын Байгаль орчны бодлогын мэргэжилтэн С.Алтанзул БОГ-ын Байгаль орчны мэргэжилтэн Б.Март
7	Нэгдсэн үзлэг, хяналт шалгалтын дүнг нэгтгэн тайлан, танилцуулга боловсруулж аймгийн Онцгой комисс болон Засаг даргад танилцуулах	2026.07.03-ны дотор	Аймгийн хэмжээнд	Ажлын хэсгийн дарга нар